



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар A/82

Батноров сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/248 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн журам)-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй "Идэрмэг 5 дугаар багийн төвийг шинээр барьж байгуулах ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээнд заагдсан хугацаанд тус ажлыг бүрэн гүйцэд хийлгэн хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ган-эрдэнэ (Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Цолмонтаяа (Соёл сангийн нягтлан
бодогч)

Н.Энхбаатар (Идэрмэг 5 дугаар багийн
Засаг дарга)

С.Хадбаатар (Иргэдийн төлөөлөгчдийн
төлөөлөгч)

Ш.Сайнбуян (Иргэн)

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, явцын чанар, ажлын тоо хэмжээ, гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд захиалагч байгууллагыг бүрэн төлөөлж хөндлөнгийн хяналт шалгалтыг тогтмолжуулан удирдлагыг мэдээллээр хангаж, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, явцын дүгнэлт, гүйцэтгэлд акт үйлдэн тус ажлыг бүрэн хүлээж авах ажлыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР